

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

2020.02.21 № 06/596
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нь батлагдсан төсвийг урсгал зардлаас хөрөнгө худалдан авсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан зэрэг нийт 342,996.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давж, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шатахууны анхан шатны баримт бүрдэл дутуу бүрдүүлсэн, зориулалт бус зарцуулсан, зардлын ангилал буруу бүртгэсэн зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу УУХҮЯ-ны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

УУХҮЯ-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор И.Эрдэнэцэцэг гүйцэтгэв.

УУХҮЯ-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/208 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх” зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавин ажиллажээ. Үүнд:

- Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Түлш (эрчим хүчний нүүрснээс бусад)-ний хангамж, нөөцийн талаарх бодлого боловсруулах, газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрийн суурийг тавьж хөгжүүлэх, улмаар дотоодын боловсруулах үйлдвэрийг байгуулах;
- Байгалийн хий болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн (нүүрсний давхаргын мятан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) талаарх судалгаа, хайгуул, олборлолтыг дэмжин хөгжүүлж, хийжүүлэх, шингэрүүлэх замаар гүн боловсруулалт хийх, ТЭЗҮ боловсруулах, боловсруулах үйлдвэр байгуулах;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхыг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх;
- Уул уурхайн салбарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, байгаль орчинд халгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

УУХҮЯ-ны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

УУХҮЯ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох компанийн “Acolous” программ хангамж ашигладаг.

УУХҮЯ-ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар УУХҮЯ-ны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь болгон сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,376,191.2 мянган төгрөгөөс тооцон 67,523.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 2 хувиар тооцсоныг гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 88,819.0 мянган төгрөгөөр тогтоосон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

УУХҮЯ-ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,383,381.3 мянган төгрөгөөр буюу 63.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	80,844.7	11,852.4	-68,992.2
Урьдчилгаа	384,999.1	438,181.3	53,182.3
Бараа материал	40,761.2	129,047.4	88,286.2
Үндсэн хөрөнгө	1,687,520.1	2,998,425.2	1,310,905.1
Нийт хөрөнгө	2,194,125.1	3,577,506.4	1,383,381.3
Өр төлбөр	45,084.7	2,986.0	-42,098.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	965,201.9	2,333,418.9	1,368,217.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,010,286.6	2,336,404.9	1,326,118.4

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа данс, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл буурсан нь ахмадын холбоо 28,328.6 мянган төгрөг, ЧД-ийн Нийгмийн даатгалын хэлтэс 792.6 мянган төгрөг, Сангийн яамнаас авах татан төвлөрүүлсэн 39,108.0 мянган төгрөгийн авлагууд барагдсан.

Авлага дансны үлдэгдэлд 11,852.4 мянган төгрөг нь ахмадын холбооноос авах 2018 онд үүссэн авлага байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 53,182.2 мянган төгрөгөөр өссөн нь уул уурхайн чиглэлээр Канад улсад зохион байгуулагддаг чуулга уулзалтын зардлыг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 34,490.0 мянган төгрөгөөр ажилчдад нормын хувцас бэлтгэсэн, 44,162.1 мянган төгрөгөөр телефон утасны аппарат, ус цэвэршүүлэгч, халаагуур гэх мэт хангамжийн материал худалдаж авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 132,667.5 мянган төгрөгийн тавилга, 237,560.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,096,737.7 мянган төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авч нийт 1,466,965.3 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, акталсан 156,060.2 мянган төгрөгийн хөрөнгөөр буурчээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд урьдчилж орсон орлогоор бүртгэсэн 38,108.0 мянган төгрөгийн орлогыг тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,333,418.9 мянган төгрөг болж 1,368,217.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны худалдан авсан хөрөнгөөр үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 5,815,507.0 мянган төгрөгийн урсгал зардлын төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,808,478.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 5,606,194.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 202,284.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж гүйцэтгэлийн шатанд 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 362,774.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 19,778.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 318,158.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 24,837.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас 318,158.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах давтан гаргахгүй албан шаардлага өгсөн.

2. Худалдаж авсан 16,878.1 мянган төгрөгийн материалыг шууд зардлаар 2,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн нь УСНББОУС-12 Бараа материал, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын холбогдох заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитаар илэрсэн 24,837.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар дараах асуудлуудыг нарийвчлан авч үзнэ. Үүнд:

1. Олон улсын чуулга уулзалттай холбоотой урьдчилж гарсан зардлын гэрээний хэрэгжилт, үр нөлөөт байдлын талаар нарийвчлан авч үзнэ.
2. Үндсэн хөрөнгөд биет тест хэрэгжүүлэх цаг хугацаа байхгүй тул завсрын аудитаар нарийвчлан авч үзнэ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

УУХҮЯ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 38 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 55,297.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Нийт 7 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийг зүй зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй байх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардлын бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаж байх гэсэн 2 зөвлөмж хэрэгжээгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид УУХҮЯ-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай санал” дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол УУХҮЯ-ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлого данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны дундуур 5,799.0 мянган төгрөгийн тендерийн орлого олсныг санхүүгийн тайланд тохируулах бичилт хийсэн тухай тайлбар тодруулга хийгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 2.20 “Орлого хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгах талаарх санхүүгийн тайлангийн тодруулгыг холбогдох УСНББОУС-ийн дагуу хийнэ” заалтыг хэрэгжүүлээгүй.

3.1.2. Эрсдэл:

Орлого бүртгээгүй байх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны бус орлого олсон тохиолдолд Сангийн сайдын 388 тоот тушаалын холбогдох заалтын дагуу бүртгэх эсвэл УСНББОУС-ын дагуу тайлбар тодруулга хийх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Төсвийн зарлагын хэмнэлтээр ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалын 5.2. "Энэ журмын 5.1.2, 5.1.3-т заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт

хэмжээ төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна." заалтыг хэрэгжүүлээгүй.

3.2.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам заавар хэрэгжүүлээгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Ажилчдын нийгмийн баталгааг холбогдох журам зааварт нийцүүлэн шийдвэрлэх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

3.3 **Зардлын данстай холбоотой асуудал**

3.3.1. Илрүүлэлт:

Шатахууны замын хуудас дутуу бөглөсөн, хэрэглэсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулдаггүй, анхан шатны баримт бүрдэл дутуу 13,038.5 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх";, 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно."заалтуудыг зөрчсөн.

3.3.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам заавар хэрэгжүүлээгүй байх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах;

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

3.4 **Зардлын данстай холбоотой асуудал**

3.4.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 6,000.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч тус зардалд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх"; Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын заалтуудыг зөрчсөн.

3.4.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам заавар хэрэгжүүлээгүй байх.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Зардлын ангиллын дагуу үнэн зөв тайлагнах;

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	505,841,961.93	595,088,324.75
33	АВЛАГА	80,081,670.93	13,881,441.21
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	792,670.93	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	39,108,000.00	
335	Бусад авлага	40,181,000.00	13,881,441.21
3351	Байгууллагаас авах авлага	40,181,000.00	13,881,441.21
34	УРЬДЧИЛГАА	384,999,067.00	438,181,339.59
34600	Урьдчилж гарсан зардал	384,999,067.00	384,999,067.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	53,182,272.59
34714	Томилолтын урьдчилгаа		53,182,272.59
35	БАРАА МАТЕРИАЛ	40,761,224.00	143,025,543.95
354	Хангамжийн материал	40,761,224.00	143,025,543.95
35410	Бичиг хэргийн материал	930,250.00	4,246,100.00
35420	Аж ахуйн материал	39,830,974.00	124,377,882.95
35430	Сэлбэг хэрэгсэл	-	9,287,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	5,114,061.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	504,444,627.66	1,760,223,757.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	504,444,627.66	1,760,223,757.12
392	Биет хөрөнгө	283,601,154.09	489,634,763.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	579,304,720.00	579,304,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(479,795,911.68)	(579,304,720.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	490,786,883.40	575,186,780.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(432,031,197.66)	(315,445,742.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	355,773,853.11	488,441,354.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	(232,171,693.08)	(260,282,127.86)
39217	Ном	1,734,500.00	1,734,500.00
393	Биет бус хөрөнгө	220,843,473.57	1,270,588,993.80
39303	Бусад биет бус хөрөнгө	259,920,148.57	1,356,657,868.57
39304	Хуримтлагдсан элэгдэл	(39,076,675.00)	(86,068,874.77)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,010,286,589.59	2,355,312,081.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	45,084,665.37	5,015,036.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,084,665.37	5,015,036.06
413	Өглөг	5,976,665.37	5,015,036.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,976,665.37	2,465,026.06
4136	Бусад өглөг	-	2,550,010.00
41361	Байгууллагад төлөх өглөг		2,550,010.00
414	Урьдчилж орсон орлого	39,108,000.00	-
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	39,108,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	965,201,924.22	2,350,297,045.81
51	Засгийн газрын хувь оролцоо	965,201,924.22	2,350,297,045.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	304,117,253.38	304,117,253.38
51101	Өмч: - төрийн	304,117,253.38	304,117,253.38
512	Хуримтлагдсан үр дүн	661,084,670.84	2,046,179,792.43
51210	Өмнөх үеийн үр дүн	661,084,670.84	661,084,670.84
51220	Тайлант үеийн үр дүн	(278,441,752.39)	1,385,095,121.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,010,286,589.59	2,355,312,081.87

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,097,749,431.98	5,809,166,247.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	867,756,431.98	688,127.00
120	Нийтлэг татварын бус орлого	867,756,431.98	688,127.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	867,756,431.98	688,127.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	855,200,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,007,304.98	688,127.00
120009	Бусад орлого	549,127.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,229,993,000.00	5,808,478,120.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,229,993,000.00	5,808,478,120.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,229,993,000.00	5,808,478,120.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,861,442,573.35	4,424,071,125.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,861,442,573.35	4,424,071,125.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,830,136,255.00	4,079,605,746.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,071,810,077.00	1,412,129,318.29
210101	Үндсэн цалин	1,071,610,444.00	869,311,941.36
210102	Нэмэгдэл	199,633.00	232,533,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	153,307,372.74
210104	Урамшуулал	-	156,976,404.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,742,598.44	140,274,400.00
210201	Тэтгэврийн даатгал	106,428,819.04	95,386,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,617,369.24	11,221,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,261,510.16	8,977,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,221,355.00	2,244,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,213,545.00	22,444,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,248,000.00	-
210304	Байрны түрээс	94,248,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	71,042,746.62	143,863,878.41
210401	Бичиг хэрэг	22,456,880.10	40,261,949.60
210402	Тээвэр, шатахуун	20,983,900.00	30,007,466.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,428,566.52	31,411,947.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,173,400.00	42,182,515.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,961,500.00	93,370,928.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	816,200.00	579,800.00
210604	Урсгал засвар	10,145,300.00	92,791,128.00
2107	Томилолт, зочны зардал	69,360,418.56	550,127,389.00
210702	Дотоод албан томилолт	69,360,418.56	550,127,389.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,205,328,192.00	1,424,187,511.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,204,530,392.00	1,414,544,457.39
210803	Даатгалын үйлчилгээ	739,300.00	7,610,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,500.00	932,334.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,100,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,642,722.38	315,652,321.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	101,566,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,642,722.38	214,086,211.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,306,318.35	344,465,378.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,700,700.00	142,181,330.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,646,100.00	91,154,189.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,054,600.00	31,617,164.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	19,409,977.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	605,618.35	202,284,048.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	605,618.35	202,284,048.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	236,306,858.63	1,385,095,121.59
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	514,748,611.02	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	514,748,611.02	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(514,748,611.02)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(278,441,752.39)	1,385,095,121.59

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,148,693,000.00	5,847,586,120.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	855,700,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	855,700,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	855,700,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	855,200,000.00	
120009	Бусад орлого	500,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,292,993,000.00	5,847,586,120.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,229,993,000.00	5,808,478,120.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,229,993,000.00	5,808,478,120.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,000,000.00	39,108,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	63,000,000.00	39,108,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,148,693,000.00	5,847,586,120.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,148,693,000.00	5,847,586,120.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,078,278,681.65	5,502,620,741.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,031,652,682.00	1,445,809,996.67
210101	Үндсэн цалин	702,722,182.00	903,838,178.53
210102	Нэмэгдэл	238,840,500.00	232,533,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	90,090,000.00	153,307,372.74
210104	Урамшуулал		156,130,845.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,725,900.00	140,461,900.00
210201	Тэтгэврийн даатгал	81,150,600.00	95,574,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,143,800.00	11,221,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,115,100.00	8,977,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,028,800.00	2,244,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,287,600.00	22,444,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,248,000.00	-
210304	Байрны түрээс	94,248,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	68,205,558.52	129,353,043.36
210401	Бичиг хэрэг	22,131,692.00	36,412,540.00
210402	Тээвэр, шатахуун	18,212,900.00	28,433,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,428,566.52	31,415,807.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,432,400.00	33,091,296.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,700.00	174,809,326.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	855,400.00	55,743,770.00
210604	Урсгал засвар	10,145,300.00	119,065,556.00
2107	Томилолт, зочны зардал	72,007,418.56	534,286,833.00
210702	Дотоод албан томилолт	72,007,418.56	534,286,833.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,655,046,422.57	2,588,374,353.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,654,248,622.57	2,536,257,299.10
210803	Даатгалын үйлчилгээ	739,300.00	7,610,220.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,500.00	932,334.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	43,574,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,392,000.00	489,525,289.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		475,989,289.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,392,000.00	13,536,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,414,318.35	344,965,378.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,700,700.00	142,181,330.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,646,100.00	91,154,189.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,054,600.00	31,617,164.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		19,409,977.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	605,618.35	202,284,048.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	605,618.35	202,284,048.78
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,108,000.00	500,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,108,000.00	500,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	-	674,777,966.23	978,895,219.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			264,748,457.00	264,748,457.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,117,253.38	-	939,526,423.23	1,243,643,676.61
Тайлант үеийн үр дүн		-	-278,441,752.39	-278,441,752.39
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	-	661,084,670.84	965,201,924.22
Тайлант үеийн үр дүн		-	1,385,095,121.59	1,385,095,121.59
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	-	2,046,179,792.43	2,350,297,045.81

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,815,507,000.00	5,606,194,071.22	209,312,928.78	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,815,507,000.00	5,606,194,071.22	209,312,928.78	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,672,152,700.00	5,464,012,741.22	208,139,958.78	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,548,730,400.00	1,444,309,996.67	104,420,403.33	93.3
210101	Үндсэн цалин	941,887,500.00	902,338,178.53	39,549,321.47	95.8
210102	Нэмэгдэл	232,533,000.00	232,533,600.00	(600.00)	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,090,000.00	153,307,372.74	16,782,627.26	90.1
210104	Урамшуулал	204,219,900.00	156,130,845.40	48,089,054.60	76.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,274,400.00	140,274,400.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	95,386,600.00	95,386,600.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,221,900.00	11,221,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,977,500.00	8,977,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,244,400.00	2,244,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	22,444,000.00	22,444,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	132,638,200.00	129,353,043.36	3,285,156.64	97.5
210401	Бичиг хэрэг	38,309,000.00	36,412,540.00	1,896,460.00	95.0
210402	Тээвэр, шатахуун	28,433,400.00	28,433,400.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,993,400.00	31,415,807.36	1,577,592.64	95.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,902,400.00	33,091,296.00	(188,896.00)	100.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,120,400.00	174,809,326.00	10,311,074.00	94.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	62,060,400.00	55,743,770.00	6,316,630.00	89.8
210604	Урсгал засвар	123,060,000.00	119,065,556.00	3,994,444.00	96.8
2107	Томилолт, зочны зардал	525,241,100.00	519,890,783.00	5,350,317.00	99.0
210702	Дотоод албан томилолт	525,241,100.00	519,890,783.00	5,350,317.00	99.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,664,158,900.00	2,579,385,903.10	84,772,996.90	96.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,609,988,400.00	2,527,268,849.10	82,719,550.90	96.8
210803	Даатгалын үйлчилгээ	7,980,000.00	7,610,220.00	369,780.00	95.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	966,000.00	932,334.00	33,666.00	96.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	350,000.00	-	350,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	44,874,500.00	43,574,500.00	1,300,000.00	97.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	475,989,300.00	475,989,289.09	10.91	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	475,989,300.00	475,989,289.09	10.91	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,354,300.00	142,181,330.00	1,172,970.00	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,354,300.00	142,181,330.00	1,172,970.00	99.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	92,101,300.00	91,154,189.00	947,111.00	99.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,753,000.00	31,617,164.00	135,836.00	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,500,000.00	19,409,977.00	90,023.00	99.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,815,507,000.00	5,606,194,071.22	209,312,928.78	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,815,507,000.00	5,606,194,071.22	209,312,928.78	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,815,507,000.00	5,606,194,071.22	209,312,928.78	99.9
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	78	78	-	100.0
620001	Удирдах ажилтан	15	15	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	60	60	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020.02.20

Аудитын нэр:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код:

САГ-2020/78/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Бараа үйлчилгээний бусад зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"	318,158.8	Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
2	Төсвийн зарлагын хэмнэлт 242,229.2 мянган төгрөгөөр ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалын 5.2. "Энэ журмын 5.1.2, 5.1.3-т заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна." заалтыг хэрэгжүүлээгүй.		Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
3	Шатахууны замын хуудас дутуу бөглөсөн, хэрэглэсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулдаггүй, хаашаа явсан утга бичдэггүй, шатахуун авсан баримт дутуу зэрэг анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн.	13,038.5	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
4	Бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шатахуун худалдан авч тус зардалд тайлагнасан.	6,000.0	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга	Г.Нандинжаргал
5	Тайлант хугацааны дундуур 5,799.0 мянган төгрөгийн тендерийн орлого олсныг санхүүгийн тайланд тохируулах бичилт хийсэн тухай тайлбар тодруулга хийгээгүй.	5799.0	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Б.Ганчимэг
Дүн		342,996.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 09 № 01/105
СЯГ-2020/78/СТА-ТЧЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа үйлчилгээний бусад зардлаас 318,158,800,00/гурван зуун арван найман сая нэг зуун тавин найм мянга найман зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.1-д "Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийлбэрээс бүрдэнэ", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан зааварт багаж, техник хэрэгслийн зардалд "... Мөн албан хэрэгцээнд ашиглагдах компьютер, принтер, скайнер зэрэг тоног төхөөрөмжийг цөөн тоогоор худалдан авах зардлыг энэ ангилалд багтаана" гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, нягтлан бодогч Б.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ
Г.НАНДИНЖАРГАЛ
Б.ГАНЧИМЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халгах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

